


- Нарны цагаан гэрлээс үүссэн өнгөнүүд нь тойрогт эрэмбэлэхэд бие биедээ алгуур уусаж, маш олон өнгө бий болгож байдаг. Үүнийг дүрслэх урлагт юу гэж нэрлэдэг вэ?
А. өнгийн ялгамж В. өнгийн нийлэмж С. өнгийн зохицол Д. өнгийн дугуй
- Өнгийн дугуйгаас эсрэг, ойролцоо, эрс тэс өнгө болон хүйтэн, дулаан өнгөнүүдийг ялган харахад хялбар байдаг. Эсрэг өнгөнүүд бие биенээ тодотгож харагдуулдаг бол хооронд нь холиход үүсэх өнгийг сонгоно уу.
А. ойролцоо өнгө үүснэ В. хүйтэн өнгө үүснэ
С. өнгийн хиртэлт үүснэ Д. дулаан өнгө үүснэ
- Зохиомж гэдэг нь найруулах зэрэгцүүлэх, жиших, эмхтгэх, өрж байрлуулах, хэсэг зүйлсийг тодорхой дарааллаар нэгдмэл байдалд оруулах зэрэг өргөн утгыг агуулдаг. Зохиомж бүтээхэд ашиглах гол зүйлийг сонгоно уу.
А. зөвхөн санаа, төсөөлөл В. дүрэм, арга, хэрэгсэл
С. зөвхөн өнгө ба хэлбэр Д. материал, багаж хэрэгсэл
- Том овор хэмжээтэй өндөр зүйлс, барилга байгууламжийг ойрын зайнаас доороос дээш эсвэл дээрээс доош харсан байдлаар орон зайг илүү бодитойгоор дүрсэлдэг алслалтын аргыг сонгоно уу.
А. нэг цэгийн алслалт В. хоёр цэгийн алслалт
С. гурван цэгийн алслалт Д. өнгийн алслалт
- Аливаа юмсыг хооронд нь, нэгийг нөгөөтэй нь жишиж зурах дүрслэх урлагийн ойлголтыг харьцаа гэнэ. Хүний биеийг дүрслэх харьцааны нэгжийг сонгоно уу.
А. толгойн өндрийн хэмжээ В. хөлний уртын хэмжээ
С. гарын уртын хэмжээ Д. биеийн өндөр хэмжээ
- Хүйтний ойролцоо өнгөтэй дүрсийн зохиомжийг сонгоно уу.



A.

B.

C.

D.

- Төрөл бүрийн зохиомж хийснээр хэлбэр дүрсүүд хоорондоо яаж зохицдог, өнгүүд бие биедээ хэрхэн нөлөөлдөг болохыг таньж зохиомжийн аргад суралцдаг. Дулааны эрс тэс өнгийн зохиомжийг сонгоно уу.




A.

B.


C.

D.


8. Хавтгайн зохиомжийг цэг, толбо, зураас, өнгө, хэлбэр, дүрс зэрэг зохиомжийн хэрэгсэлүүдээр хийдэг. Цэгээр зурсан хавтгайн зохиомжийг сонгоно уу.




9. Зураасаар зохиомж хийхдээ бараан өнгийн цаасан дээр цагаан зураасаар, цагаан болон тод гэрэлтэй өнгийн цаасан дээр хараар гэх мэт эрс тэс өнгийн ялгаралтай зохиомж хийж болно. Дүрсийг хүрээлэх байдлаар зураасыг дахин давтаж хийсэн хавтгайн зохиомжийг сонгоно уу.



10. Дүрсүүдийн давтамжийг эмхлэн цэгцэлж, уялдаа холбоотойгоор байрлуулж нэгтгэх үндсэн зарчмыг хэмнэл гэж үздэг. Тэгш өнцөгт дүрс ашиглан хийсэн уран бүтээлийн зохиомжийг сонгоно уу.



11. Гурван цэгийн алслалтын аргаар дүрсэлсэн барилгын зургийг сонгоно уу.




A.

B.

C.

D.

12. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзлэхүүнийг алслалтын аргаар дүрслэхэд харааны түвшний шулуун болон уулзалтын цэгүүдийг оновчтой тодорхойлох шаардлагатай. Нэг, хоёр, гурван цэгийн алслалтын байгуулалтыг барилга байгууламжийн дүрслэлтэй харьцуулан ажиглаад, зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.



1.


2.

3.

A.

B.

C.




A. 1-A, 2-C, 3-B

B. 1-B, 2-A, 3-C

C. 1-A, 2-B, 3-C

D. 1-B, 2-C, 3-A

13. Аливаа биет харааны түвшний шугамаас дээш, харааны түвшинд давхцах, харааны түвшний шугамаас доош гэсэн гурван байршилд алслалттай харагддаг. Хоёр цэгийн алслалтын аргаар биетийн эзлэхүүнийг дүрсэлсэн зургийг ажиглаад, биетүүдийн байршлыг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.



- A. А болон В биет харааны түвшний шугамаас дээш, С биет харааны түвшинд цаана, D болон Е биет харааны түвшний шугамаас доош байршиж байна.
- B. А болон В биет харааны түвшний шугамаас дээш, С биет харааны түвшинд давхцах, D болон Е биет харааны түвшний шугамаас доош байршиж байна.
- C. А болон В биет харааны түвшний шугамаас дээш, С биет харааны түвшинд давхцах, D болон Е биет харааны түвшинд байршаагүй байна.
- D. А болон В биет харааны түвшний шугамаас доош, С биет харааны түвшинд давхцах, D болон Е биет харааны түвшний шугамаас дээш байршиж байна.
14. Хүн бүрийн биеийн харьцаа өндөр, намаас шалтгаалж өөр өөр байдаг. Биеийн өндрийн дундаж нь аарцаг дээр буюу хажуу талаас ташаан толгой дээр байна. Хүний биеийн өндрийг хэмжих харьцааны нэгжтэй зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.
- | | |
|----------------------|----------------------------|
| 1. Нярай хүүхэд | a. толгойн өндөр 5-6 дахин |
| 2. 6 настай хүүхэд | b. толгойн өндөр 4 дахин |
| 3. 12 настай хүүхэд | c. толгойн өндөр 6.5 дахин |
| 4. Насанд хүрсэн хүн | d. толгойн өндөр 7 дахин |
- A. 1-с, 2-а, 3-б, 4-д B. 1-с, 2-б, 3-а, 4-д C. 1-а, 2-б, 3-с, 4-д D. 1-б, 2-а, 3-с, 4-д
15. Натюрмортыг зохиомж, байгуулалт, гэрэл сүүдэр гэсэн гурван үе шаттай зурдаг. Гэрэл, сүүдрийг зурааслах аргаар дүрсэлж илэрхийлснээр эд юмсын харагдах байдлыг сонгоно уу.
- A. Зохиомж, байгуулалт ойлгомжтой харагдана.
- B. Өнгөний зохицол ойлгомжтой харагдана.
- C. Шинж чанар, орон зай тодорхой харагдана.
- D. Зураасны ялгамж тодорхой харагдана.
16. Тухайн биетийн хэлбэр дүрс, орон зай, эзлэхүүн зэрэг гадаад шинжид тохирсон зураасны төрлийг сонгон дүрсэлдэг. Бөмбөрцөг гадаргуутай биетийн гэрэл, сүүдрийг дүрслэхэд тохиромжтой зураасны төрлийг сонгоно уу.
- A. шулуун зураас B. тахир зураас C. махир зураас D. нуман зураас


17. Усан будгаар эд юмсын гэрэл сүүдрийг илэрхийлэхдээ нэг өнгөөр дагнаас хийсэн аргын адилаар хамгийн цайвар, гэрэлтэй, хөнгөн өнгөөс эхлэн дүрсэлдэг. Гуашаар эд юмсын гэрэл сүүдрийг илэрхийлэх зөв аргыг сонгоно уу.

- A. Гэрэлтэй хэсгийн өнгийг эхэлж бичээд, сүүдэртэй хэсгийг сүүлд нь зурна.
- B. Сүүдэртэй хэсгийн өнгийг эхэлж бичээд, гэрэлтэй хэсгийг сүүлд нь зурна.
- C. Суурь өнгө хатсаны дараа хүнд өнгөөр сүүдэртэй хэсэгт давхарлан зурна.
- D. Цайвраас бараан өнгө рүү, өмнөх өнгөө хатсан хойно нь давхарлан зурна.

18. Уран бичлэг нь дүрслэх урлагийн зураасан зургийн нэг төрөл бөгөөд бичиг үсэг үүсэх цагаас өнөөг хүртэл олон төрлөөр хөгжсөөр ижээ. Өргөн, нарийн зураас болон үсгийн дээд, доод талд тойргийн байгуулалтыг ашигладаг уран бичлэгийн төрлийг сонгоно уу.

- A. Гротеск-дармал үсэг
- B. Уран сайхан үсэг
- C. Антиква-хэрчмэл үсэг
- D. Шрифт үсэг


19. Зурааслах аргаар гэрэл сүүдрийг илэрхийлэн гурван хэмжээст биет зураг зурж болно. Бөмбөрцөгийн гэрэл сүүдрийг зурааслах аргаар зурсан зургийг сонгоно уу.



A.



B.



C.




D.

20. Натюрмортын гэрэл сүүдрийг усан будгаар уусгаж будсан зургийг сонгоно уу.



A.



B.



C.




D.

21. Уран бичлэгийн антиква төрөл нь хуучны, үнэ цэнэтэй, гоёмсог, чамин мэдрэмж төрүүлдэг онцлогтой. Антиква төрлийн үсгийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

22. Бар зургийг мод, хулдаас, чулуу, төмөр, зэс дээр ухах, хонхойлох, сийлэх аргаар хэв хийж, цаасан дээр барлан дардас гарган олшруулдаг онцлогтой. Хулдаасан бар зургийг сонгоно уу.



A.



B.




C.



D.

23. Натюрмортын гэрэл сүүдрийг гуашаар бичилт хийж будсан зургийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

24. Ардын зураач А.Сэнгэцохио “Уургач” зургийн дүрүүдийг ажиглаад, тохирох хариуг сонгоно уу.



А.Сэнгэцохио
“Уургач”

- A. Зургийн гол дүрийг томоор дүрсэлж, үйл явдлыг монгол зургийн аргаар зурсан.
- B. Зургийн гол ба туслах дүрийг ижил хэмжээтэй дүрсэлж, уран зургийн аргаар зурсан.
- C. Зургийн гол ба туслах дүрийг томоор дүрсэлж, өнцөглөсөн зохиомжийн аргаар зурсан.
- D. Зургийн гол дүрийг товойлгон үзүүлэхийг чухалчлаагүй, задгай зохиомжийн аргаар зурсан.

25. Монгол зурагт орон зай илэрхийлэхдээ бийрийн даралт таталтаар үүсэх зураасны өргөн нарийн хэлбэр, өнгийн дагнаасын алгуур уусалт, шилжилт зэрэг уран сэтгэлгээний аргууд ашиглан зурдаг. Ардын зураач Б.Шарав “Айрагны баяр” зургийн хэсгийн зохиомжийг ажиглаад, тохирох хариуг сонгоно уу.



Б.Шарав. “Айрагны баяр” зургийн хэсэг

- A. Зурагт юмс, үзэгдлийг дүрслэхдээ хавтгайд тараан байрлуулж, орон зайн өвөрмөц өгүүлэмжээр илэрхийлэн, өнцөглөсөн зохиомжтой.
- B. Зургийн гол дүрийг томоор дүрсэлж, үйл явдлыг монгол зургийн аргаар, харааны цэгийг төвлөрүүлэн тэгш хэмийн зохиомж бүхий дүрслэлтэй.
- C. Зурагт уудам их орчинд болж байгаа олон үйл явдлыг нэг хавтгайд байрлуулж, дүрүүдийг тиг ашиглан дүрсэлсэн хоорондоо уялдаа холбоо бүхий зохиомжтой.
- D. Зургийг их өндөрлөгөөс харсан мэт харааны олон цэгийн байгууламжтай, үйл явдлыг хүүрнэн өгүүлэх хэлбэрээр, монгол зургийн аргаар задгай зохиомжтой.